

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолыг үг дуугүй бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө»¹⁸ гэж тэр их хурлаас заасан байна. Ингэж МАХН, ардын засгийн газраас хятадын хувьсгалт дэвшилт хүчинтэй хамтран Монгол, Хятадын харилцааг хэвийн болгохын төлөө их хүч чармайлт гарган тэмцсэн нь зохих үр дүнд хүрчээ.

ЗАРЛААГҮЙ ДАЙНЫ ЭХЭН ҮЕ Б. Чантуу

Монгол Зөвлөлтийн ард түмний найрамдлын бат бэхийг дайсан нэг биш туршин үзсэн бөгөөд Халхын голын районд болсон байлдаан Монгол Зөвлөлтийн ахан дүү армийн хамтын ялалтаар түүхэнд алтан үсгээр бичигдэн үлдсэн юм.

Халхын голын байлдааны ялалт нь империалист түрэмгийлэгчдийн эсрэг ах дүү социалист хоёр орны армийн хороо дивизүүд нэгдмэл командын дор хамтран амжилттай байлдаж ялан дийлсэн анхны туршлага байв. 1930-аад оны үед Японы милитаристууд БНМАУ-ыг түрэмгийлэн эзлэхийг санаархаж байсан юм. 1934 оны арван нэгдүгээр сарын 24-нд ЗСБНХУ-ын засгийн газар БНМАУ-ын засгийн газрын хүсэлтээр манай улстай аман хэлэлцээр байгуулсан ёсоор, хэрэв манай хоёр орны аль нэгэн рүү халдан довтолох аюул учирвал харилцан бие биедээ тусламж үзүүлэх тухай үүрэг авсны дотор цэргийн тусламж ч үзүүлэхээр хэлэлцэн тохирсон билээ. Энэ нь цаг үеэ олсон хэлэлцээр байв. 1935-1936 онд Японы түрэмгийлэгчид манай

1. Советско-монгольские отношения. 1921—1974. М., 1975, Т-1, с, 104,
2. Монгол-Зөвлөлтийн харилцаа, 1921—1974. УБ., 1975, боть I, 106 дахь тал.
3. МАХН-ын V их хурал. УБ., 1926, 21 дэх тал,
4. МАХН-ын V их хурал, УБ., 1926, 21 дэх тал.
5. НТА. Ф-1, Д— 32, ХН 5, 109-110 дахь тал
6. «Үнэн», 1926, № 83.
7. МАХН-ын их, бага хурал, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр, 1 дэвтэр, УБ., 1956, 104 дэх тал.
8. М. С. Капица, В. И. Иваненко, Дружба, завоеванная в борьбе, М., 1965, . с, 157,
9. НТА, ф. 1, Д-2, ХН—176, 14 дэх тал.
10. Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх. УБ., 1981, 85—86 дахь тал.
11. Намын VII их хурлаар сонгогдсон Төв Хорооны II бүгд хурлын товч тогтоол, УБ, 1929, 3 дахь тал.
12. БНМАУ-ын Зэвсэгт хүчний архив. Ф-1, Д. 3, ХН—75.
13. Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх. УБ, 1981, 87 дахь тал.
- 14 НТА, Ф-1, Д. 3, ХН-165, 10—11 дэх тал.
15. Коминтерн и Восток. М., 1969, с. 331.
16. МАХН-ын их, бага хурал. Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр, хэсэг, УБ., 1956, 278 дахь тал.
17. «Үнэн». 1931 оны долдугаар сарын 2.
18. Советы в Китае, М., 1933, с. 440—441.

Б. Чантуу. «Улаан од» сонины ерөнхий эрхлэгч

улсын дорнод хил дээр удаа дараа зэвсэгт өдөөн хатгалга хийсээр байсан боловч тухай бүр няцаагдсаар байв. Тэр үеэс ЗХУ-ын засгийн газар «Хэрэв Японы зүгээс БНМАУ-д довтолхоор шийдэж, түүний тусгаар тогтнолд аюул учруулахад хүрвэл ЗХУ, БНМАУ-д 1921 онд тусалсныхаа нэгэн адилаар тусална» гэсэн мэдэгдлийг бүх дэлхийд зарлан тунхагласан билээ. Японы түрэмгийлэгчид БНМАУ-ын дар хан хил хязгаарыг зөрчиж, өдөөн хатгах нь 1939 оны нэгдүгээр сараас улам идэвхжиж, тавдугаар сар хүртлэх хугацаанд цэргийн их бага хүчээр тус улсын хил хязгаарыг 30 гаруй удаа зөрчсөн байна.

Япончууд «бага хүчний» идэвхтэй байлдааны ажиллагаагаар монгол Зөвлөлтийн цэргийн анхаарлыг татаж манжид төвлөрүүлсэн квантуны армийн гол хүчээр ЗХУ-ын Алс дорнодын нутаг Уссури, Амар муж, Хабаровскийн районд нэвтэрч Приморийн хязгаарыг богино хугацаанд эзлэн авахаар төлөвлөсөн байжээ. Энэ төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд японы түрэмгийлэгчид 1939 оны тавдугаар сарын 11-нд их буу, нисэх онгоцоор дэмжүүлсэн 500 шахам морьт цэргийн хүчээр БНМАУ-ын нутагт цөмрөн орж, Халхын гол дахь зарлаагүй дайныг эхэлсэн юм. Г. К. Жуков «Халхын голын зарлаагүй дайн» гэдэг номондоо «Ах дүү монголын ард түмнийг хүнд бэрх цагт орхихгүй байх нь пролетарийн интернационалч үүрэг мөн гэж зөвлөлтийн дайчид бид сайн мэдэж байв» гэж цохон тэмдэглэжээ. Халхын голын үйл явдал нь жирийн нэгэн хилийн мөргөлдөөн биш социалист, капиталист хоёр ертөнцийн тэмцлийн талбар болсон юм. Хоёр талын зорилго, төлөвлөгөө, ажиллагааны шинж чанараас үндэслэж:

— **1939 оны тавдугаар сарын 11-нээс 8 дугаар сарын 20 хүртэл монгол Зөвлөлтийн цэргийн ангиуд японы цэргийн давшилтыг няцааж, шийдвэрлэх тулалдаанд бэлтгэсэн үе.**

— **1939 оны 8 дугаар сарын 20-ноос мөн сарын 31 хүртэл монгол зөвлөлтийн цэргийн шийдвэрлэх давшилтын үе гэсэн хоёр үндсэн үе шат болгон тодорхойлж болно.**

Халхын голын байлдааны эхний үе шат буюу 5 дугаар сарын 11-нээс 8 дугаар сарын 20 хүртэлх хугацаанд япончууд урьдчилан бэлтгэсэн давуу хүчээр Халхын голын районд Монгол Зөвлөлтийн цэргийн тэргүүн ангиудыг бут цохиж, ашигтай байр эзлээд, амжилтаа цааш өрнүүлэх зорилгоор 5-7 дугаар сард хэдэн удаа давшилт хийхийг оролдсон юм. Энэ үед Монгол, Зөвлөлтийн цэрэг дайсны давшилтыг идэвхтэй хориглолтоор няцааж, дайсанд аль болох их хохирол учруулж, хүчийг нь сулруулан шийдвэрлэх давшилт хийж, японы түрэмгийлэгчдийг бут цохин устгахаар бэлтгэж байв.

Хүчний харьцааны хувьд буудлагын болон морьт цэрэг, пулемет, танк эсэргүүцэх хэрэгслээр японы цэрэг 1,3—2,5 дахин их, харин газрын их буу, хуягт машинаар монгол-зөвлөлтийн цэрэг 1,5—5,6 дахин давуу байв.

Квантуны армийн штаб БНМАУ-ын Дорнод хязгаар Халхын голд Японы эзэн хааны шилдэг ангиудаар бүрдсэн цэргийн үлэмжхэн хүчийг хуримтлуулж «Номон ханы давшилт» гэдэг их давшилт хийхээр шийдвэрлэж Номонхан, Бүрд овооны орчимд урьдчилан татаж бэлтгэсэн их буу, нисэх онгоцоор дэмжүүлсэн 2500 гаруй цэрэг бүхий их хүчээр 5 дугаар сарын 11 болон 28, 29-ний өдрүүдэд монгол, зөв-

лөлтийн цэргийн ангиудыг хоёр талаас нь ороож бүслэхийг оролдсон боловч хатуу цохилт амсаж, олон зуун хүнээ гарздаж, БНМАУ-ын Хилийн цаана хөөгдөн гарсан юм. Байлдааны эхэн үед Япон-Манжгогийн цэргийн хүч Номон хаан, Бүрд овоо, Хайлаастайн голын дагуу довтолсон боловч монгол зөвлөлтийн цэргийн түрүүчийн ангиудад цохигдож 400 гаруй цэрэг офицероо алдаж зэр зэвсгийн ихээхэн хохирол хүлээжээ. Японы цэргийн анхны довтолгоог бут цохиход хошууч Ч. Маарийбуугийн командалсан МАХЦ-ын 6 дугаар морьт дивиз, мөн дивизийн дэслэгч Л. Дандарын командалсан 17 дугаар морьт хороо, зөвлөлтийн армийн хошууч И. М. Ремизовын командалсан 149 дүгээр хорооныхон эрэлхэгээр тулалдаж ялсан юм.

Японы цэргийн командлал энэ бүтэлгүй ажиллагаандаа дүгнэлт хийгээд монгол, Зөвлөлтийн цэрэгт гэнэтийн цохилт өгч Халхын голын баруун эргийг эзлэх зорилт тавьж, 6 дугаар сарын турш шинэ давшилтад бэлтгэн, 1939 оны 7 дугаар сарын эхээр БНМАУ-ын хилийн дагуу 38 мянган цэрэг, офицер, 310 их буу, 135 танк, 225 нисэх онгоц хуралдуулсан байв. Японы цэргийн нисэх хүчний тактикийн үндсэн бодлого нь нэгдүгээрт: нисэх онгоцоор хэзээ ч давуу байх. хоёрдугаарт: Монгол-Зөвлөлтийн нисэх онгоцыг шатах, тослох материалынхаа ихэнхийг зарцуулж дууссаны дараа эсэргүүцэн байлдах, гуравдугаарт: 1000 метрийн өндөрт онгоцоо хэдэн давхар нисгэж доод давхрын онгоц нь манайхны дайрагч онгоцтой тулалдаж байхад дээд давхрын онгоцууд нь аль тохиромжтой талаас довтолон дайрч устгах, дөрөвдүгээрт: Монгол-Зөвлөлтийн ганц нэгээр ниссэн онгоцыг уулны цаанаас гэнэт дайран сөнөөх зорилготой байв. Японы цэргийн энэ удаагийн давшилтын ойрын зорилго нь Халхын голын зүүн эрэгт байсан Монгол-Зөвлөлтийн цэргийн анги нэгтгэлийг бүслэн цохих, цаашид манай бэлтгэл хүчийг цохих зорилгоор Халхын голыг гатлан баруун эрэгт гарч, эзэлсэн газраа бэхжүүлж улмаар өргөтгөх эрмэлзэлтэй байлаа.

Японы цэргийн командлал энэ тулалдааныг долдугаар сарын эхний хагаст явуулж, улмаар манай улсын нутаг дэвсгэр дээр хийх байлдааны ажиллагааг намар болохоос өмнө дуусгахаар төлөвлөсөн байжээ.

Хүчний харьцааны хувьд Монгол Зөвлөлтийн цэргээс япончууд явган цэрэг болон их буугаар 3 дахин, морьт цэргээр 4,5 дахин давуу болсон тул энэ удаагийн байлдаанд амжилт олно гэж баттай итгэсэндээ фашист Герман, Итали зэрэг гадаад орнуудын цэргийн атташе, сурвалжлагч нарыг фронтын шугамд урьж ирүүлэхээ ч мартсангүй. Монгол-Зөвлөлтийн цэргийн командлал 1939 оны 7 дугаар сарын 2-ны шөнө Тамсагбулагаас Зөвлөлтийн цэргийн танкийн 11 дүгээр бригад, 7 дугаар мото хуягт бригад, мото буудлагын хороо зэрэг хөдөлгөөнтэй том хүчийг Баянцагаанд яаралтай хөдөлгөжээ.

Баянцагааны байлдаан гэж алдаршсан 7 дугаар сарын 4, 5-нд өдөржин, шөнөжин болсон ширүүн тулалдаанд хоёр талаас 400 орчим танк, хуягт машин, 300 гаруй их буу, хэдэн зуун нисэх онгоц оролцож, япончууд бараг бүх танкаа, бас их бууныхаа ихэнхийг алдаж, 45 нисэх онгоц, 10 мянга орчим хүнээ устгуулж Халхын голын зүүн эрэгт арга буюу ухран гарсан юм. Японы цэргийн гол хүчийг ингэж бут цохисноор 7 дугаар сарын 5-ны өглөө Баянцагааны нуруу, Халхын голын баруун эрэгт нам жим болж энэ тулалдаан шувтрав. Түү-

нээс хойш Халхын голын баруун эрэгт японы цэрэг хөл тавихыг зүрхэлсэнгүй.

Баянцагааны тулалдааны туршид Зөвлөлтийн дайчид, ялангуяа бригад командлан захирагч М. П. Яковлевийн удирдсан танкийн 11 дүгээр бригад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ. Ер нь Баянцагааны тулалдаан шиг хуяг танкийн нэгтгэл ангиудыг байлдаанд өргөн ашиглаж, гол үүрэг гүйцэтгэж байсан туршлага урьд өмнө гарч байгаагүй юм.

Баянцагааны тулалдааны өмнөхөн Г. К. Жуков бригад командлан захирагч Яковлевтэй уулзаж:

— Танкийн бригадаар явдал дундаас, дахин хэлье, Зогсолтгүй явдал дундаас дайралтад ор! Танайхыг Монголын ангиуд дэмжинэ гэж тушаав.

— Явган цэрэг яах вэ?

— Дараа нь ирнэ.

— Нөхөр командлагч аа! Дүрэмд...!

— Мэдэж байна, нөхөр бригад командлан захирагч. Энэ тухай дүрэмд огт заагаагүй. Гэвч цагийн байдал үүнийг шаардаж байна.

— Мэдлээ нөхөр Командлагч аа! гээд Михаил Павлович ёслов.

Цагийн байдал ингэж шийдвэртэй өөрчлөгдлөө. Чин зоригт хошууч Константин Абрамов (хожим ЗХУ-ын баатар цол шагнуулсан) 1939 оны 7 дугаар сарын 3-нд Зөвлөлтийн улаан армийн дайчин, чадварлаг танкчны үлгэр жишээ үзүүлэн дайсны цуваа руу дайрч танкуудыг нь халз мөргөн дараа дараагаар жагсаалаас гаргаж байжээ. Хэдийгээр тэр үед дэлхийн аль ч орны зэвсэгт хүчний байлдааны дүрэмд танкийг байлдаанд явган цэрэггүйгээр ашиглах тухай заалт байгаагүй боловч энэ зоримог шийдвэр туйлын зөв болох нь үйл явдлын өрнөлтийн дараагийн шатанд тодорхой болсон юм. Эх орны дайны үед энэ үзэл санаа улам хүчтэй хөгжин дайсны хориглолтыг сэтэлсний дараа танкийн армиуд ерөнхий цэргийн армиудаас хол тасран дайсны оперативын гүнд амжилттай давшиж байсан билээ.

Бас манай нисэх хүчинд цохилт өгч өөрийн цэргийн том давшилтыг хангахын тулд японы цэргийн командлал агаарын довтолгооноо идэвхжүүлснээр 1939 оны 6, 7 дугаар сард бараг өдөр бүхэн агаарын тулалдаан болж заримдаа агаарын томоохон байлдаан болтол өргөждөг байв. Жишээлбэл 7 дугаар сарын 10-нд хоёр талаас нэгэн зэрэг 180 онгоц, мөн 21-нд 300 орчим онгоц оролцсон агаарын ширүүн байлдаан болжээ. Эдгээр байлдаанд японы цэргийн командлал хятадад байсан нисэх хүчний ангиудаасаа хамгийн шилдэг нисгэгчдээ оролцуулж байв.

ЗХУ өндөр мэдлэг, туршлагатай нисгэгчидтэй тухайлбал алдарт нисгэгч Я. В. Смушкевич тэргүүтэй цөм ЗХУ-ын баатар 21 хүний бүрэлдэхүүнтэй нисгэгчдийг шинэ маягийн «И-16», «Чайка» сенөөгч нисэх онгоцны хамт Халхын голд ирүүлсэн юм. Эдгээр нисгэгчид болон сенөөгч нисэх онгоц ирснээс хойш япончуудын агаарт давамгайлах нь эцэс болж, 7 дугаар сарын 23-наас 8 дугаар сарын 4 хүртэлх хугацаанд япончууд 116 нисэх онгоцоо алдсан байна.

Монгол-Зөвлөлтийн цэргийг бүслэн устгахаар давшилтад орсон Японы цэргийн шигшмэл ангиуд Баянцагааны тулалдаанд бүрмөсөн сүйрч байлдааны санаачилгыг буцалтгүй алдсан явдал тэдний зайлшгүй ялагдаж сөнөхийн дохио болсон юм. Танк механикжуулсан цэрэг,

нисэх хүчин болон түргэн хөдөлгөөнт их буугийн ангиудыг харилцан ажиллуулж байлдахад тодорхой зорилго бүхий шуурхай давшилт л шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдгийг Баянцагааны тулалдааны туршлага харуулжээ.

Баянцагааны тулалдаанд хурандаа Л. Дандарын командалсан манай армийн 6 дугаар морьт дивизийн ангиуд, Ч. Дугаржавын командалсан 23 дугаар хороо, Шагдарын хуягт дивизион, Е. Төрхүүгийн удирдсан их бууны батарей гарамгай байлдаж, Зөвлөлтийн армийн хошууч И. М. Ремизовын командалсан 149 дүгээр хороо, М. П. Яковлевийн танкийн 11 дүгээр бригад, И. И. Федюнинскийн 24 дүгээр хороо, Н. И. Полянскийн их бууны 175 дугаар хороо гарамгай байлдаж онцгой гавьяагаараа тодорчээ. Баянцагааны домогт тулалдаан нь зэвсэг техник, галын маш их нягтрал, төрөл бүрийн цэргийн асар их бөөгнөрөлтэй үлэмж ширүүн тулалдаан болсон бөгөөд түүний ялалтаар Халхын голын байлдааны цаашдын төлөвийг шийдвэрлэж, байлдааны санаачилгыг Монгол, Зөвлөлтийн талд авчирсан юм. Японы цэргийн командлал 8 дугаар сард шинэ шийдвэрлэх давшилтад орохоор бэлтгэж явган цэргийн хоёр дивиз, 1 бригад, танкийн 2 хороо, их буугийн 7 хороо (үүнээс 4 нь хүнд их буугийн) баргын морьт цэргийн 3 хороо, танк эсэргүүцэх хэд хэдэн батарей, Порт-Артураас бэхлэлтийн хүнд их буу, хятадын фронтоос туршлагатай нисгэгчдээ татан ирүүлж, Халхын голын районд 75 мянга гаруй хүн, 500 их буу, 182 танк, 350 орчим нисэх онгоц хуралдуулжээ. Энэ их цэрэг, зэвсгийн хүчээ 6 дугаар арми болгон зохион байгуулж, командлагчаар генерал Огису Риппог томилон 8 дугаар сарын 24-нд ерөнхий давшилтаа эхлэхээр төлөвлөсөн байв. Энэ үед Монгол зөвлөлтийн цэргийн командлал өөрийн цэргийн ерөнхий давшилтаар Японы цэргийн бүлэглэлийг БНМАУ-ын хилийн дотор бүслэн устгах шийдвэрлэх операцын төлөвлөгөө боловсруулсан юм. Энэ төлөвлөгөө ёсоор операцид оролцох шинэ нэгтгэл, ангиудыг 7—8 дугаар сард Халхын голын районд татан ирүүлж, тэнд 57 мянга гаруй хүн, 498 танк, 385 хуягт машин, 542 их буу, миномет, 2255 пулемёт болон 515 нисэх онгоц хуралдуулжээ.

Монгол-Зөвлөлтийн цэргийн ерөнхий давшилтыг 8 дугаар сарын 20-нд эхлэхээр төлөвлөсөн нь дайсны давшилт эхлэхээс өрсөх гол зорилготой байв. Давшилтад бэлтгэх явцад материал техникийн хангалттай холбогдсон их ажил хийсэн бөгөөд байлдааны районд ойр төмөр зам байхгүй байсан нь цэрэг татах материалын нөөцийг хуралдуулахад ихээхэн бэрхшээл учруулж, авто тээврийн үүргийг улам нэмэгдүүлжээ.

Армийн 1 дүгээр бүлгийн командлал Монгол-Зөвлөлтийн цэргийн шийдвэртэй цохилтыг эсэргүүцэн сөрөх маневр хийх бололцоог дайсанд өгөхгүйн тулд оператив тактикийн ажиллагаандаа өнгөлөн далдлах, хууран мэхлэх аргыг чадамгай хэрэглэсэн нь манай цэргийг удаан хугацааны хориглолт хийж байна гэсэн төөрөгдлийг япончуудад төрүүлсэн юм. Дайсан манай талын утсан холбоо, радиог чанган тагнадаг байсан болохоор манайхан харилцаандаа зориуд хориглон хамгаалалтын барилга барих, намар өвлийн ажилд бэлтгэх тухай ярьж байв. Фронт дээр дуу чимээний хүчтэй станц ажиллуулах, хориглолтын ажиллагааны дууриамал цууриа нэвтрүүлэх, асар их хориглолт, бэхлэлт хийж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж байв. Давшилт эхлэх байранд танкийн хүч хуралдуулахдаа шөнийн бөмбөгдөгч онгоц нисгэх, гар пулеметын буудлага хийх, утааны яндангүй их дуутай хэд

хэдэн танкийг ийш тийш явуулах зэргээр дайсныг мэхэлж байсан ажээ.

Ерөнхий давшилт хийх гэж байгаагаар дайсанд сэжиг авахуулахгүйн тулд төлөвлөгөөг боловсруулахад зөвхөн фронтын цэргийн зөвлөлийн гишүүд, улс төрийн хэлтсийн дарга, штабын дарга, оперативын хэлтсийн дарга нарыг оролцуулжээ. Ерөнхий давшилтын төлөвлөгөөг давшилт эхлэхээс хоёрхон хоногийн өмнө төрөл бүрийн цэргийн ангийн дарга нарт танилцуулсан бөгөөд цэрэг түрүүч нарт гуравхан цагийн өмнө байлдааны тушаал өгчээ. Монгол-Зөвлөлтийн цэргийн командлалын гол зорилт нь цэргийн хүчтэй группээр дайсныг хоёр хажуугаар нь ороон бүсэлж устгахад чиглэсэн юм. Энэ зорилтоо биелүүлэхийн тулд бүх цэргийн хүчээ Өмнөд, хойд, төв гэсэн гурван хэсэгт хуваажээ. Цэргийн урлагийн түүхэнд 1930-аад оны дундуур боловсруулсан «Гүн давшилтын онол»-ыг 1939 оны 8 дугаар сард Халхын голын байлдаанд Монгол-Зөвлөлтийн цэрэг анх хэрэгжүүлжээ. Энэ онолын мөн чанар нь артиллер, танк, механикжуулсан цэрэг, нисэх болон агаарын десантын анги, нэгтгэлүүдийн хүчээр, дайсны оперативын бүх гүнд нэгэн зэрэг цохилт өгөх зорилготой байв.

Давшилтад бэлтгэх явцад дайчдын дотор нам, улс төрийн ажил эрчимтэй өрнүүлж, цэрэг, дарга нарыг аймшиггүй эрэлхэг зоригтой, дайсныг үзэн ядах, түүнийг түргэн бут ниргэхийн тулд давших өндөр эрмэлзэлтэй, ялалтад төгс итгэх бат итгэлтэй болгох талаар нэгтгэл ангиудын нам, улс төрийн байгууллага их ажил зохиолоо. Дайчдад улс төрийн ухамсар, ёс суртахууны өндөр чанар олгох хэрэгт «Баатарлаг улаан арми», «Эх орны төлөө» сонинууд, байлдааны хуудас, янз бүрийн санамж их тус хүргэсэн байна. Цэргийн доторхи нам, эвлэлийн байгууллага бэхжиж, гишүүдийн тоо түргэн өсөж байв. Монгол-Зөвлөлтийн цэрэг 1939 оны 8 дугаар сарын 20-ны өглөө бүх фронтоор нэгэн зэрэг давшилт эхэлжээ. Ингээд Халхын голын байлдааны хоёр дахь үндсэн үе эхэлж, 8 дугаар сарын 31 хүртэлх 10 гаруй хоногийг хамарчээ.

Халхын голын байлдааны эхэн үеийн тухай өгүүлэхдээ хоёр дахь үеийг орхихгүйг хичээн доорхи хэдэн өгүүлбэрийг бичье. Зөвлөлт Монголын цэрэг Халхын голын районд милитарист японы 75 мянган хүнтэй армийг бүслэн бут ниргэсэн нь тухайн үедээ цэрэг дайны түүхэнд гарсан ховорхон үзэгдлийн нэг, социализмын ууган хоёр орон—ЗСБНХУ, БНМАУ-ын нийгэм төрийн байгууллагын бат орших давуу тал, манай хоёр ард түмний ах дүүгийн мөнх найрамдал, тэдгээрийн армиудын дайчин нөхөрлөлийн аугаа их хүч чадал, сүр жавхлангийн яруу тод илрэл болсон юм.

Халхын голын байлдааны ялалтыг удирдан зохион байгуулагч, зоригжуулагч хүч нь ЗХУКН, МАХН мөн. Манай ах дүү хоёр орны марксист ленинист намуудын мэргэн удирдлага, нэгдэл нягтрал Халхын голд түүхэн ялалт байгуулах үндсэн эх сурвалж болсон юм.

Арми, ард түмний холбоо, нэгдэл, бат бэх ар тал, ЗХУ-ын социалист эдийн засгийн хүч бололцоо, хүнд аж үйлдвэрийн хүчирхэг хөгжил нь Халхын голын байлдааны фронтыг шаардлагатай бүх материаллаг хэрэгслэлээр тасралтгүй хангаж, ялалт байгуулах чухал нөхцөлийг бүрэлдүүлсэн юм.

Халхын голын байлдааны бүх үеийн туршид зөвлөлт-Монголын дайчид нэг нуувчинд хамт хориглож, байлдааны талбарт мөр зэрэг-

цэн давшиж, дайсны сумнаас нэг нэгнийгээ амь биеэрээ хамгаалж, баяр бахдал, хүнд бэрхийг чин зүрхнээсээ хуваалцаж байсан сэтгэл хөдлөм жишээ олныг дурдаж болно. Зөвлөлтийн армийн анги, нэгтгэлүүд Халхын голын байлдааны фронтын хамгийн гол чиглэлд ажиллаж, хамаг хүнд хүчрийг өөртөө хүлээж ялалт байгуулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэснийг онцлон тэмдэглэх ёстой.

Монгол-Зөвлөлтийн цэргийн зэвсэг, техникийн байлдааны хүч чадлын давуу чанар нь даргалах бүрэлдэхүүний ур чадвар, ялах эрдэм ухаан, анги зэвсэг нэгт дайчдын эх оронч, интернационалч үзэл сурталтдаа бүрэн итгэсэн бат итгэл нь японы түрэмгийлэгчдий бут цохисон ялалтын бас нэг чухал эх сурвалж болсон юм. Халхын голын байлдааны цэргийн урлагт чухал хувь нэмэр оруулж, үнэтэй туршлага хуримтлуулсан билээ. Монгол зөвлөлтийн армийн командлал зам харилцааны зангилгаа, хангах баазаас алслагдсан хээр талын нөхцөлд төрөл бүрийн мэргэжлийн олон анги, нэгтгэлийн их хүчийг хуралдуулах давших операцыг нууцаар бэлтгэн явуулж, дайсны цэргийн томоохон бүлэглэлийг бүслэн устгасан нь цэрэг дайны түүхэнд урьд бараг гарч байгаагүй чухал зүйл болсон юм. Өөр нэгэн бахархах зүйл бол аугаа их эх орны дайны үед Дээд Ерөнхий командлалын орлогч байсан, суут жанжин, ЗХУ-ын 4 удаагийн баатар, БНМАУ-ын баатар, ЗХУ-ын маршал Г. К. Жуковын цэргийн эрдэм авьяас, оператив-тактикийн гүн сэтгэлгээ байлдаанд цэрэг удирдах чадвар нь чухам л Халхын голд анх тодорсон юм. Тэрчлэн Зөвлөлтийн пуужинт зэвсгийг анх удаа амжилттай хэрэглэж туршсанаар Халхын голын байлдааны төгсгөлийн агаарын тулалдаан ихээхэн онцлогтой болжээ.

1939 оны 8 дугаар сарын 20-нд зөвлөлтийн туршин нисгэгч ахмад Н. И. Зворнаревийн удирдсан «И—16» сөнөөгч нисэх онгоцны зүг нэг км зайнаас 5 пуужин зэрэг харваж дайсны хоёр онгоцыг сөнөөжээ. Түүний дараа болсон тулалдаануудад зөвлөлтийн алдарт нисгэгчид энэ зэвсгээрээ Халхын голд японы 13 нисэх онгоцыг устгасан байна. (МАХН, ЗХУКН социализмын төлөө ах дүү ёсоор хамтран тэмцсэн түүхэн туршлага. УБ. 1971 он. 252 дахь тал.) Энэ дайнд дайсан амьд хүч, зэвсэг техникийн асар их хохирол үзсэн юм. Зөвхөн 7, 8 дугаар сарын тулалдаанд Япон 19 мянга шахам цэрэг, офицероо устгуулж, 25 мянга орчим хүнээ шархдуулсан юм. 1939 оны 5 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл хугацаанд дайсан 52—55 мян ган цэрэг, офицероо алджээ. Бас 200 гаруй их буу, 660 нисэх онгоцоо устгуулсан юм.

Халхын голын байлдаан монгол-зөвлөлтийн цэргийн бүрэн ялалтаар төгсөж дайны гал зогсоох актад 1939 оны 9 дүгээр сарын 6-нд гарын үсэг зуржээ. Халхын голын байлдаанд гарамгай гавьяа байгуулсан учир Сүхбаатарын нэрэмжит 6 дугаар дивиз, хилийн цэргийн 7 дугаар заставыг Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор, МАХЦ-ийн дайчдаас 726 хүнд зөвлөлтийн улаан армийн туслан хамгаалах ангийн 300 илүү дайчдыг БНМАУ-ын төрийн дээд шагнал одон медалиар шагнаж, Л. Гэлэгбаатар, Ц. Олзвой, Л. Дандар, Д. Гуулин, Н. Жамбаа, Ч. Дугаржав, Д.Хаянхярваа, П. Чогдон, Д. Самдан, Д. Нянтайсүрэн, Б. Цог, С. Төмөрбаатар, М. Экей, Г.К. Жуков, М. П. Яковлев, К. Н. Абрамов, И. М. Ремизов, Я. В. Смушкевич, С. И. Грицевец, Г. П. Кравченко, И. И. Федюнинский зэрэг 100 гаруй хүнд БНМАУ, ЗХУ-ын баатрын эрхэм цол олгожээ.

Халхын голын байлдааны ялалт нь ах дүү социалист аль ч оронд хар санаат хэн нэгэн гурав дахь этгээд түрэмгийлэн халдвал тэдний хамтын хүчнээс ямар хариу авч болохыг яруу тод илтгэн харуулсан Халхын голын байлдааны ялалтын түүхэн сургамж өнөө ч чухал ач холбогдолтой хэвээр байна. Халхын голын байлдааны ялалтын түүхэн сургамжийг дэлхийн олон улс орон бахархан тэмдэглэхдээ дэлхийн II дайны урьдал байсан гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

**СУНЬ ЯТСЕН БА Монгол
(1911-1924 ОН)
Ц. Батбаяр**

Хятадын ард түмний үнэнч хүү, цогт ардчилсан хувьсгалч Сунь Ятсен (1866—1925) ялалт бахархал ялагдал гашуудал хосолсон зөрчил тэмцлээр дүүрэн амьдралын замыг туулсан юм. Түүнийг бид 1911 оны цагаагчин гахай жилийн хувьсгалын (Синьхайн) эцэг, Хятадын анхны бүгд найрамдах улсын түр ерөнхийлөгч, «ардын гурван зарчмыг» зарлан тунхаглагч гэсэн талаас нь илүү мэддэг билээ. Харин тэрээр хэдэн зуун жилийн гүн нойроос сэрсэн Азийн ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл, түүн дотор Монголын ард түмний тэмцэлд хэрхэн хандаж байсан нь төдийлөн тодорхойгүй.

Тухайн үедээ В. И. Ленин Сунь Ятсений үзэл бодлын үндсэн агуулгыг задлан шинжлээд, түүний үзэл санааг «дайчин ардчилал»-ын шинжтэй гэж тодорхойлжээ. Сунь Ятсеныг «ариун санаа ба баатарлаг чанараар» нэвтэрхий ардчилсан хувьсгалч гэж нэрлэхийн хамт В. И. Ленин түүний үзэл бодлын сөрөг талыг ил тод харж байв. Тухайлбал 1912 онд бичсэн өгүүлэлдээ тэрээр Сунь Ятсений «жигжиг хөрөнгөтний үл гүйцэлдэх», тэр ч байтугай зарим харгис үзэл бодлыг түүний үзэл санааны «хувьсгалт ардчилсан гол хэсгээс» тусад нь салган шүүмжлэхийн чухлыг тэмдэглэж байжээ.¹ Синьхайн хувьсгалын дараа хятад биш үндэстний талаар баримталж байсан Сунь Ятсений үзэл бодолд мөн ийм байр сууринаас хандах нь оновчтой.

Цагаагчин гахай жилийн хувьсгал, түүнтэй холбогдон хуучин манж Чин улсын зах хязгаар нутаг, ялангуяа Монголын байдал Сунь Ятсений анхаарлыг татаж ямар нэг хэмжээгээр түүний сэтгэлийг түгшээж байв. 1912 оны нэгдүгээр сард Бээжинд хүрэлцэн ирсэн монгол ноёдод илгээсэн илгээлтдээ тэрээр “Монголын байдал туйлын түгшүүртэй» байгааг анхааруулж байсан нь санамсаргүй зүйл биш юм.² Сунь Ятсен зах хязгаар нутагт өдрөөс өдөрт өрнөж байгаа салан тусгаарлах хөдөлгөөнийг өөрийн нүдээр ажиглан харж байв. Шударга ёсны төлөө Ухань хот анхлан боссоны дараа арав гаруй муж газар дараа дараалан тусгаар тогтнолоо зарлаж, манж Чин улсын засаг